



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/174

Хэрлэн сум

Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн өргөдөл гаргасан иргэнд холбогдох бичиг баримтыг үндэслэн газар эзэмших эрхийн гэрчилгээг хавсралтад дурдсанаар 1 иргэний 1 нэгж талбарыг шилжүүлсүгэй.


2.Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан иргэнд газар эзэмших эрхийн гэрчилгээг олгож, гэрээ байгуулан биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг газрын мэргэжилтэн (Ц.Зулжаргал)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбоотойгоор сумын Засаг даргын 2014 оны 186 тоот захирамжийн дээрх иргэнд холбогдох заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР



Хэрлэн сумын Засаг даргын 2025 оны
06 дугаар сарын 17-ны өдрийн 17/06
захирамжийн хавсралт

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх нэрсийн жагсаалт

д/д	Шилжүүлсэн иргэн ААНБ-ын нэр	Газрын зориулалт	Газрын хэмжээ	Эзэмшил газрын байршил	Шилжүүлэн авсан иргэн ААНБ-ын нэр	Хугацаа	Шилжүүлэх үндэслэл	Нэгж талбарын дугаар
1	Жаргал Отгонгэрэл /ЕЭ69041762/	Гэр орон сууцны хашааны газар	300 м2	Хэнтий, Хэрлэн 4-р баг, Сариг, МСҮТ-1 гудамж 10 тоот	Эрдэнэбат Батзаяа /СТ93082011/	9	Эрх шилжүүлэх гэрээ	2311023141